

ЦЭРГИЙН СТРАТЕГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХӨГЖИЛ, СУДЛАХ ЗҮЙЛ

Б.Цэдэндамба

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, дэд хурандаа

Товч агуулга: Хил хамгаалалтын стратегийн хөгжлийн талаар тодорхой мэдлэгтэй байхыг удирдах албан тушаалд ажиллаж байгаа офицерын бүрэлдэхүүнээс өнөөгийн цаг үе, нөхцөл байдал зүй ёсоор шаардаж байгааг тул юуны өмнө Цэргийн стратегийн тухай ойлголт, хөгжил, судлах зүйлийн талаар ойлгуулахыг зорив.

Abstract: Since the present time and situation rightfully demands from the officers in the management positions to have a certain knowledge about the development of the border defense strategy, first of all, I aimed to make them understand the concept, development and study of the military strategy.

Түлхүүр үг: Стратеги, Цэрэг, Хөгжил, Судлах зүйл, Зорилт

Keywords: Strategy, Troops, Development, Exploration, Objectives

Оршил

Цэргийн стратеги улс төрийн бодлого, зорилттой нягт холбоотой, түүний зорилго нь улс төрийн бодлого, зорилгод захирагдаж байдаг зүй тогтолтой. Иймээс цэргийн стратегийн ажиллагааны хувьсал өөрчлөлт, цэрэг улс төрийн байдлын онцлогоос хамаарч ямагт бага хүч хэрэгслээр, хохирол багатай ялалтад хүрэхийг зорьдог билээ.

Стратегийн мэдлэг боловсролыг ном, сурах бичиг, судалгааны бүтээлүүдийг уншиж судалсанаар эзэмшиж болох ч ур чадвар, дадлагыг зөвхөн практик ажиллагаа, туршлага, сургамжийг биеэр үзэж байж өөрийн болгодог жамтай.

Энэхүү зорилго зорилтыг хэрхэн хэрэгжүүлэх нь цэргийн стратегичдээс бүрэн хамаарах бөгөөд тэдний стратегийн онолын мэдлэг, ур

чадвар, боловсрол, түүнийгээ хэрхэн хэрэгжүүлэх нь хувийн хичээл зүтгэл, хариуцлагаас хамаарч байдаг юм.

НЭГ.ЦЭРГИЙН СТРАТЕГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Стратеги гэдэг нь Грекийн “Strgatos”-цэрэг, “ago”- залж жолоодох гэсэн үгнээс гаралтай бөгөөд грекийн ойлголтоор стратегийг- цэргийг жолоодох урлаг, жанжны урлаг гэж үздэг¹.

Стратеги гэдэг ойлголт нь МЭӨ Ази болон Европт бараг нэгэн зэрэг үүсч бий болохдоо цэрэг дайны шинжтэй, тулааны талбарт дайныг хэрхэн төлөвлөх, өрнүүлэх, ялалтад хэрхэн хүрэх, дайснаа хэрхэн сүйрүүлэх зэрэг утга агуулгатай байв. Эртний Грект армийн удирдагчийг “Стратегич” (στρατηγός strategos) гэж хамгийн анх нэрлэсэнээр энэ үг хэрэглээнд орж ирсэн байдаг.

¹ Ш.Паламдорж, Ц. Дашзэвэг, “Зэвсэгт хүчни стратеги”, 2017.23 дах тал

Цэргийн тактик, бүслэлт, логистик гэх мэт хэд хэдэн ур чадваруудыг багтаасан "Жанжны урлаг" гэсэн утгаараа энэ нэр томъёо нь МЭ VI зуунд Зүүн Ромын нэр томъёонд ашиглагдаж, барууны хэл рүү XVIII зуунд орчуулагдсан байдаг. Түүнээс хойш XX зууныг хүртэл "Стратеги" гэдэг үг нь дайснууд хоёулаа дайсагнасан цэргийн мөргөлдөөнд "Хүсэл зорилгын диалектикаар хүч хэрэглэх, заналхийлэх, бодитоор ашиглах зэрэг улс төрийн зорилгоо биелүүлэхийг оролдох цогц арга замыг" илэрхийлэх болсон байна.

Стратеги гэдэг нэр томъёо цэргийн хэргийн төдийгүй бусад шинжлэх ухааны салбарт улам түгэж, нийтлэг шинжтэй болсон байдаг.

Жишээ нь Орчин үед стратегийг их олон янзаар тодорхойлох болсон хэдий ч хамгийн энгийн бөгөөд маш зөв ойлголт өгөх тодорхойлолт гэвэл: Тодорхойгүй нөхцөлд нэг ба хэд хэдэн зорилгод хүрэх дээд зэргийн төлөвлөгөө гэж "Стратеги: Түүх" ("*Strategy: A History*") номондоо Сэр Л.Фридман (*Sir Lawrence Freedman*) стратегийг тодорхойлсон байдаг.

Харин стратеги хэмээх нэр томъёоны тодорхойлолтыг шууд утгаар нь түүхэн хөгжлийн явцад эрдэмтэд, цэргийн жанжидууд тодорхойлсон байдаг.

1. Австрийн Эрц Герцог Карл: "Стратеги бол дайны тухай шинжлэх ухаан юм. Тэр нь цэргийн операцийн явцыг төлөвлөж, учир шалтгааныг нь олж, тодорхойлдог жинхэнэ дээд ерөнхий жанжны шинжлэх ухаан юм."

2. Генрих Бюлов /1757-1807/ "стратеги бол их буугаар буудаад

үл хүрэх, хараанаас гадна болж байгаа цэргийн хөдөлгөөний тухай, харин тактик бол энэ хязгаарын дотор болж байгаа цэргийн хөдөлгөөний тухай шинжлэх ухаан юм.¹ "

3. Анри Жомини /1779-1869/ "стратеги бол ямар нэгэн орон руу түрэмгийлэн дайрхад ч, өөрийн орныг хамгаалахад ч дайны талбар дээр олон түмнийг чадварлаг удирдах урлаг юм." Энэ бүхнийг нэгтгэн үзвэл стратеги нь онол практикийн нэгдлийг илэрхийлэгч нэр томъёо болж байна.

4. Д.Доржготов /1948-2010/ "Цэргийн стратеги гэдэг нь орчин үеийн дайны шинж чанар, дайныг цэргийн хэрэгслээр зайлуулах арга зам, түрэмгийллийг няцаахад улс орныг бэлтгэх, дайн, стратегийн цар хэмжээний цэргийн ажиллагаа явуулах арга, хэлбэрийн тухай шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоо бөгөөд тэдгээрийн тайван ба дайны цагт залж жолоодох талаарх төрийн болон тэдгээрийн дээд удирдлагын практик үйл ажиллагааны салбар юм."

Энэ бүхнээс бид цэргийн стратеги гэсэн нэр томъёо юуг хэлж тайлбарлаад байгаа тухай дараах дүгнэлтийг хийж байна.

1. Цэргийн шинжлэх ухаан, зэвсэгт тэмцлийн тухай мэдлэгийн тогтолцоо юм.

2. Цэрэг-улс төрийн дээд удирдлага, командлал, ерөнхий штабуудын үйл ажиллагааны цогц юм.

Үүнээс үзэхэд цэргийн стратеги гэсэн нэр томъёо нь цэргийн урлагын мэдлэгийн тогтолцоо, шинжлэх ухаан, цэргийн удирдлагын практик үйл ажиллагаа, удирдахуйн урлагыг багтаасан ойлголтыг илэрхийлж болно.

¹ Ш.Паламдорж, Ц. Дашзэвэг., "Зэвсэгт хүчний стратеги", 2017.31 дах тал

Цэргийн стратеги нь цэргийн шинжлэх ухааны бүрэлдэхүүн бөгөөд операцийн урлаг, тактикийн харьцуулахад, тэдгээрийн дээд хүрээ, дээд түвшний урлаг юм. Цэргийн стратеги дайн зэвсэгт мөргөлдөөнийг явуулах хэрэгсэл, аргыг ашиглах, хэрэглэх тухай цэгцтэй мэдлэгийн тогтолцоо, шинжлэх ухаан юм.

Цэргийн стратеги дайн, зэвсэгт мөргөлдөөнд операцийн урлаг, тактикийн ажиллагааг ашиглаж ялалт байгуулах тухай онол, практикийн нэгдэл, цэргийн жанжны удирдахуйн урлаг юмаа.

Цэргийн стратеги нь цэргийн практик үйл ажиллагааны хувьд: Зэвсэгт хүчний стратегийн зорилтыг тодорхойлж, түүнд шаардлагатай хүч хэрэгслийг урьдчилан тооцож, болзошгүй дайнд хүн ам, эдийн засаг, байлдааны ажиллагааны хувилбар, зэвсэгт хүчнийг бэлтгэх, стратегийн операцыг төлөвлөх, зэвсэгт хүчнийг дэлгэн байрлуулах, дайны нөхцөлд цэргийн удирдлагыг зохион байгуулах, болзошгүй дайсны дайн, стратегийн операц хийх арга, боломжийг судладаг. Цэргийн стратеги нь улс орны эдийн засгийн байдал, нийгмийн байгууламж, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түвшин, хүн амын улс төр, ёс суртахууны байдлаас ихээхэн хамааралтай байдаг.

Цэргийн стратегийн тухай ойлголт нь түүнийг бүрдүүлэгч үндсэн нэр томьёо, тэдний агуулгатай салшгүй холбоотой байдаг бөгөөд тэдгээрийг дурьдвал: Цэргийн стратегийн бүрэлдэхүүн хэсэг, цэргийн стратегийн тагнуул, стратегийн төлөвлөлт, үндсэн цохилтын чиглэлд хүч хэрэгслийг төвлөрүүлэх, стратегийн өнгөлөн далдалт, стратегийн дэлгэн байрлуулалт, дайсанд стратегийн хуурамч мэдээлэл тараах, стратегийн

командлал, стратегийн удирдлагын байр, цэргийн стратегийн нөөц, стратегийн дэд бүтэц, стратегийн холбоо, стратегийн төлөвлөгөө, стратегийн давамгайлал, стратегийн байршил эзлэх, стратегийн цохилт гэх мэт байна.

Цэргийн стратеги нь байнгын хөдөлгөөнтэй байж, цэргийн үйл ажиллагааны урьдчилсан төсөөлөл, баримжааллын асуудлыг судлаж, ялан дийлэх, няцаах арга ухааныг шинжлэх үүрэгтэй цэргийн шинжлэх ухаан юм.

Цэргийн стратегийн агуулга нь дараах байдлаар тодорхойлно.

1. Орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанар, зүй тогтол,
2. Орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэж буй зэвсэглэл, ашиглаж буй цэрэг техникийн цогцолбор, хамгаалалтын хэрэгслийн төвшин
3. Дэлхий даяаршил, геоулс, цэрэг улс төрийн нөхцөл байдал
4. Өөрийн улсын улс төрийн /батлан хамгаалах/ бодлого
5. Өөрийн улсын эдийн засгийн чадавх, үйлдвэрлэх хүчний хөгжлийн төвшин
6. Цэргийн шинжлэх ухааны ололт, амжилт, онолын боловсруулалтын төвшин

ХОЁР. ЦЭРГИЙН СТРАТЕГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Стратеги гэдэг ойлголт нь анх МЭӨ Ази болон Европт бараг нэгэн зэрэг үүсч бий болохдоо цэрэг дайны шинжтэй, тулааны талбарт дайныг хэрхэн төлөвлөх, өрнүүлэх, ялалтад хэрхэн хүрэх, дайснаа хэрхэн сүйрүүлэх зэрэг утга агуулгатай байв.

Эртний улсуудад цэргийн стратегийг судлах оролдлого хийгдэж байв.

Үүнд:

- Хятадын цэргийн жанжин, цэргийн онолч Сун-зы (V-VI зууны МӨӨ)-Цэргийн урлагын тухай шастир;

- Ромын жанжин Юли Цезарь (I зууны МӨӨ) Ромын түүхч Фронтин, Оносандр (I зууны МӨӨ) нарын өгүүллэгүүд;

- Энэ үед том тулалдаан ховор болдог байв. Энэ нь XV зуун хүртэл Европын цэргийн стратегийг зогсонги байдалд оруулсан гэж үздэг байна.

Цэргийн стратегийн хөгжлийг дараах цаг үетэй холбон үздэг.

1. Цэргийн стратеги
феодалын улсуудад үүссэн нь (XV зуун хүртэл)

2. XIII-XIV зууны Монгол цэргийн стратеги

3. Төвлөрсөн улсуудад цэргийн стратеги үүсэн тогтносон нь (XVI-XVII зуун)

4. Шинжлэх ухаан техникийн хувьсгалын үеийн цэргийн стратегийн хөгжил (XIX зууны 2-р хагас-XX зууны эхэн)

5. Дэлхийн 1-р дайны үед цэргийн стратеги хөгжсөн нь (1914-1918)

6. Дайнуудын хоорондох үеийн цэргийн стратегийн хөгжил (1924-1939)

7. Дэлхийн 2-р дайны үеийн цэргийн стратегийн хөгжил.

8. Дайны дараах үеийн цэргийн стратегийн хөгжил.

XIII-XIV зууны Монгол цэргийн стратеги

Монгол цэргийн урлаг нь стратеги, тактикийн төвшинд, үүнээс стратеги нь хэрхэн хөгжиж ирсэнийг тайлбар гаргалгаагаар нотлож болох

юм. Хамгийн анхдагч үзүүлэлт бол Чингис хаан аян дайны бэлтгэлийг хангаж, аян дайн явуулж байсан түүхэн үйл явдлууд харуулдаг. Эрдэмтэн Х.Шагдар өөрийн бүтээлдээ дурьдсан байдаг.

Их монгол улсын цэргийн стратеги нь : аян дайны санаачилгыг эхнээс нь гартаа авдаг, байлдааны ажиллагааг тасралтгүй, идэвхтэй явуулдаг байсан нь ямагт ялан дийлэхийн үндэс суурь болж байдаг байсан. Тэд цэргийн тоог олшруулахаас илүүтэй цөөлөх, чанаржуулах стратегийг баримтладаг байсан юм. Тиймээс “цөөнөөс цөөн гарз” гэсэн уриатай байсан ажээ. Энэ нь цөөнөөр олныг ялах ухаан буюу орчин үеийн цэргийн урлаг, стратегийн мөн чанарыг нээсэн хэрэг юм.

Мөн Их Монгол Улсын цэргийн стратегийн үндсийг маневрын стратеги бүрдүүлж байсанаараа бусдаас онцлог юм. Орчин үеийн цэргийн шинжлэх ухаанд стратегийн төвшинд маневрыг цэргийн бүлэглэл, гал, цохилт, хамгаалалтын хөдөлгөөн, шилжилтээр хангаж буйг маневрын стратеги гэж нэрэлдэг байна. Энэ стратегийг Чингис хаан бүлэглэлээр явуулж байсан юм¹.

Монгол цэргийн стратегийн талаар гадаадын эрдэмтэд өөрийн бүтээлд тусгасан байдаг билээ жишээ: Марко Поло /1254-1324/ өөрийн тэмдэглэлдээ монгол цэргийн зэр зэвсэг, монгол цэргийн шинж чанар, тактикийн зарим асуудлуудыг дурьдсан байдаг.

Монгол цэргийн урлагийн түүхийг дэлгэрэнгүй авч бичсэн хүн бол Оросын дэслэгч генерал Михайл Иванин /1801-1874/ юм. Тэрээр Монгол

¹ Ш.Паламдорж, Ц. Дашзэвэг., “Зэвсэгт хүчни стратеги”, 2017.17 дах тал

цэргийн урлагийн түүхийг авах гээхийн ухаанаар авч үзсэн байдаг.

Цэргийн стратегийн тухай онолын ойлголт, түүнийг хөгжүүлэх асуудал, монгол цэрэгт бүрэлдэн төлөвших явц зөвхөн XX зууны дунд үеэс, дэлхийн 2 дугаар дайны дараа 1953 оноос цэргийн дээд командлалын дарга нарыг ЗХУ-н Зэвсэгт хүчний Жанжин штабын академид бэлтгэж эхэлсэн цагаас эхэлсэн байх магадлалтай гэж үздэг.

ГУРАВ. ЦЭРГИЙН СТРАТЕГИЙН СУДЛАХ ЗҮЙЛ, ЗОРИЛТ

Танин мэдэх болон практик үйл ажиллагаа бүр нь өөрийн объект, судлах зүйлтэй харин онол нь түүнээс

гадна өөрийн категори, зүй тогтол зарчмуудтай байдаг.

Цэргийн стратегийн салбарт практик болон танин мэдэх үйл ажиллагааны объект нь-дайн юм.

Цэргийн стратегийн салбарт үйл ажиллагааны болон танин мэдэх зүйл, судлагдахуун нь дайны гол онцлог тал болох -зэвсэгт тэмцэл юм.

Цэргийн урлагын онол нь өргөн цар хүрээтэй үүргийг шийдвэрлэдэг бөгөөд тэдгээрийн дотроос хамгийн чухал нь болох цэргийн ажиллагааг бэлтгэж явуулах арга, хэлбэр, төрөл, зарчмуудыг судалдаг¹.

Энэ онол нь: Стратеги, оперативын урлаг, тактикийн онолыг багтаадаг

Цэргийн удирдлагын онол

Стратеги

Оператив

Тактик

Стратегийн онол- Зэвсэгт хүчний бүх төрөлд нэгдмэл байх бөгөөд цэргийн урлагын онолд тэргүүлэх байр эзэлдэг.

Цэргийн стратегийн судлах зүйлийн тодорхойлолт нь агуулгын шинжтэй байдаг

Цэргийн стратегийн агуулгыг тодорхойлдог элементүүд

-Өнөөгийн эрэн үеийн дайны болзошгүй шинж чанар, юуны өмнө түүний стратегийн агуулга болон дайныг цэргийн хэрэгслээр зайлуулах арга зам;

-Түрэмгийллийг няцааж бут цохих зорилгоор явуулж байгаа дайн, стратегийн операцид зэвсэгт хүчний

үүрэг, түүнийг биелүүлэхэд шаардагдаж байгаа хэрэгсэл;

-Дайн, стратегийн операцийг бэлтгэн явуулах арга, хэлбэр, нөхцөл;

-Болзошгүй дайн, стратегийн операцид зэвсэгт хүчний болон түүний төрлүүдийг хэрэглэх стратегийн төлөвлөлт;

-Зэвсэгт хүчний ажиллагааны ёс суртахуун-сэтгэл зүй, ар тал техникийн болон стратеги (оператив)-ийн хангалтын үндэс;

-Тайван ба дайны цагт зэвсэгт хүчнийг залж жолоодох;

-Цэргийн ба зэвсэгт хүчний байгуулал, дайнд улс орны эдийн засаг, хүн ам, нутаг дэвсгэрийг бэлтгэх

¹ Д.Доржготов. "Цэргийн стратегийн үндэс", УБ., 2008

талаарх заавар зөвлөгөө, шаардлагыг боловсруулах;

-Болзошгүй дайсны стратегийн үзэл бодол, түүний дайн явуулах эдийн засгийн болон цэргийн боломж, дайн, стратегийн цар хэмжээний операци явуулах (үүсгэх) арга;

Дүгнэлт

Стратеги нь ихээхэн хүч, хөдөлмөр зарцуулж, цаг хугацаа, орон зайг эзэлж байж хэрэгждэг учир төрийн бодлого, хууль эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтын дараалсан ажил, арга хэмжээ, хариуцах эзэн холбогдогч-байгууллага, албан тушаалтны хичээл зүтгэл, идэвх санаачилга, шургуу хөдөлмөр, туйлбартай чанар, зориг тэвчээр гаргахыг шаарддаг. Үүний үрээр стратеги хэрэгжих үндсэн нөхцөл бүрдэх юм.

Стратегийн удирдлагыг удирдагч, манлайлагч нар явуулж, түүнийг бусад бүрэлдэхүүн, иргэд хэрэгжүүлнэ. Ухаалаг, өндөр мэдлэг боловсролтой стратегчид удирдлагыг хэрэгжүүлэх арга замыг заана. Стратегийг хэрэгжүүлэх үйл явцыг стратегийн удирдлага болох субъект зохион байгуулна. Стратеги нь удирдахуйн шинжтэй бөгөөд түүнгүй бол стратегийн шинжгүй юм.

Ашигласан эх сурвалж

1. Ш.Паламдорж, Ц. Дашзэвэг., “Зэвсэгт хүчний стратеги”., УБ, 2017.
2. Ш.Паламдорж, Ц. Дашзэвэг., “Батлан хамгаалах стратеги”., УБ., 2017.
3. Д.Доржготов. “Цэргийн стратегийн үндэс”., УБ., 2008